



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 10 сарын 10 өдөр

Дугаар 0/350

Улаанбаатар хот

「Баянзүрх дүүргийн 267 дугаар цэцэрлэгийн」
эд хөрөнгийг данснаас дансанд
шилжүүлэн бүртгэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсэг, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны А/82 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2024 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Машин, тоног төхөөрөмжийн дансанд бүртгэлтэй нийт 3,600,000.00 (гурван сая зургаан зуун мянга) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий эргэлтийн бус хөрөнгийг үндсэн хөрөнгийн холбогдох дансанд шилжүүлэн бүртгэхийг Баянзүрх дүүргийн 267 дугаар цэцэрлэг (Б.Байгалмаа)-т зөвшөөрсүгэй.

2.Хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартыг баримтлан бүртгэж, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Баянзүрх дүүргийн 267 дугаар цэцэрлэг (Б.Байгалмаа)-т үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, ашиглалт, дотоод аудитын хэлтэс (Г.Тэмүүжин)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

В.Оюумаа

В.ОЮУМАА



Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 100 дугаар тушаалын хавсралт



Данснаас дансанд шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Баянзүрх дүүргийн 267 дугаар цэцэрлэг

Д/д	Хөрөнгийн нэр	Марк, дугаар	Ашиглалтад орсон өгнөөр	Чанар байдал	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Бүртгэх анхны үнэ		Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	Дансны нэр	
							Нэгж үнэ	Нийт үнэ			Шилжүүлэх данс	Бүртгэх данс
1	Бэлтгэлийн ширээ	никель	2022.09.30	сайн	ш	1	1,200,000.00	1,200,000.00	480,000.00	720,000.00	Машин тоног төхөөрөмж	Тавилга, эд хогшил
2	Гүйдэг хаалгатай ширээ	никель	2022.12.19	сайн	ш	1	1,200,000.00	1,200,000.00	420,000.00	780,000.00	Машин тоног төхөөрөмж	Тавилга, эд хогшил
3	Ажлын ширээ	никель	2023.10.31	сайн	ш	1	1,200,000.00	1,200,000.00	125,000.00	1,075,000.00	Машин тоног төхөөрөмж	Тавилга, эд хогшил
	Тавилга, эд хогшлийн дүн							3,600,000.00	1,025,000.00	2,575,000.00		